

2025

ЖИЛИЙН ТАЙЛАН

АЛСЫН ХАРАА

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ “УХААЛАГ” СҮЛЖЭЭ БОЛОХ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

1. Мэдлэг, ур чадвар, хүний хөгжил
2. Аюулгүй байдал
3. Багаар ажиллах
4. Шинэ санаа, бүтээлч сэтгэлгээ
5. Шударга, хариуцлагатай байдал
6. Компанийн нэр төр


НЭГДСЭН СТРАТЕГИ ҮР ДҮН


Чадварлаг хүний нөөц, дэвшилтэт техник технологи бүхий үндэсний дамжуулах сүлжээ болно.

ТАНИЛЦУУЛГА

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компани нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу стратегийн ач холбогдол бүхий 100 хувь төрийн өмчит хаалттай хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Эрчист Монгол ХХК эзэмшиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Эрчим хүчний салбарын төрийн өмчит зарим компанийн талаар авах арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Эрчим хүчний Сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Арга хэмжээ авч ажиллах тухай” А/259 дүгээр тушаалын дагуу Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний систем ТӨХК, Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн дамжуулах сүлжээг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д нэгтгэж, Алтай-Улиастай, Баруун бүсийн салбар шинээр байгуулагдаж, 177.8 МВА хүчин чадалтай 11 дэд станц, 1184.5 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам шилжин ирж, нийт 220 кВ, 110 кВ-ын 6,362.8 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 98 дэд станцын ашиглалт, засварын үйл ажиллагааг хариуцан Монгол Улсын 19 аймгийг эрчим хүчээр тасралтгүй хангах үүрэг хүлээж, энэхүү үүргээ төв удирдлага, болон Улаанбаатар салбар, Хангайн бүсийн салбар, Төвийн бүсийн салбар, Зүүн-Өмнөд бүсийн салбар, Говийн бүсийн салбар, Алтай-Улиастайн салбар, Баруун бүсийн салбартайгаар өндөр хүчдэлийн дэд станц, агаарын шугамаар дамжуулан хэрэгжүүлж байна.





Байгуулагдсан он: 1967

Салбар: 7

Ажилтны тоо: 1444

Суурилагдсан хүчин чадал: 5701 МВА

Нийт ЦДАШ-ын трассын урт: 6,362.8 км

220 кВ-ын ЦДАШ-ын трассын урт 2,016.3 км

110 кВ-ын ЦДАШ-ын трассын урт 4,322.1 км

35 кВ-ын ЦДАШ 24.4 км

Нийт дэд станц: 98

220 кВ-ын дэд станц 11

110 кВ-ын дэд станц 86


35 кВ-ын дэд станц 1

Хамрах хүрээ: Монгол Улсын нутаг дэвсгэрийн 82.3 хувь /1,287,267 км²/, хүн амын 95.9 хувийг хамарч, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Баянхонгор, Төв, Дорноговь, Дундговь, Хэнтий, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий зэрэг 19 аймгийн 301 сум суурин газар

Дамжуулалтад авсан ЦЭХ : 8,935.6 сая.кВт.цаг

Тусгай зөвшөөрлүүд:

- Цахилгаан дамжуулах үйл ажиллагаа,
- Цахилгаан импортлох (БНХАУ-аас),
- Эрчим хүчний барилга байгууламж-80 МВт-ын эрчим хүчний хуримтлуурын систем барих
- 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын, засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх,
- Эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах,
- Монгол улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх,



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Гишүүний нэр	Албан тушаал	Гишүүний төрөл
О.Хуягцогт	ТУЗ-ийн дарга, ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	Дарга
Б.Нармандах	ЭХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын ахлах шинжээч	Гишүүн
Г.Гэрэлт-Од	ЭХЯ-ны Салбарын хяналтын газрын Цахилгаан техникийн аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн	Гишүүн
Э.Ганчимэг	тэтгэвэрт	Гишүүн
Г.Дэлгэрмаа	ТӨБЗГ-ын Удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны мэргэжилтэн	Гишүүн
Ж.Арслан	ШУТИС-ийн профессор	Хараат бус гишүүн
Л.Одмаа	ТӨБЗГ-ын архивын эрхлэгч	Хараат бус гишүүн
Л.Долгорсүрэн	тэтгэвэрт	Хараат бус гишүүн

ТУЗ-ийн үйл ажиллагааны тойм

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэн нийт 15 удаа хуралдаж, 38 асуудлыг хэлэлцэн 31 тогтоол, 14 тэмдэглэл гаргасан.

Хэлэлцсэн гол асуудлууд:

- 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт
- Компанийн зохион байгуулалтын бүтэц өөрчлөлт — Баруун бүсийн болон АУС-ийн нэгтгэл
- Ажилтнуудын цалин хөлс нэмэгдүүлэх, нэмэгдэл хөлс олгох
- 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт
- 2026 оны зардлын төсөв, ИЗА, ТЗБАХ, ХО-ын төлөвлөгөөний төсөл
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах материал, тайлан
- Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, нийт ажилтнууд аа,

2025 он “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хувьд үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж, стратегийн төслүүд бодитоор хэрэгжиж эхэлсэн, компанийн хөгжлийн дараагийн шатанд шилжсэн онцлох жил байлаа.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Баруун бүсийн болон Алтай-Улиастайн эрчим хүчний системийн дамжуулах сүлжээг нэгтгэн авч, нийт 6,362.8 км урт 220 кВ болон 110 кВ-ын шугам, 98 дэд станцын ашиглалт, засварыг хариуцан ажиллах болсон нь бидний хариуцлага, стратегийн ач холбогдлыг шинэ шатанд гаргасан.

2027 болон 2035 он хүртэлх хөгжлийн түвшинг тодорхойлсон техникийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, системийн найдвартай ажиллагаа, эрсдэлийн удирдлагыг сайжруулах “Сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх” төлөвлөгөөтэй болов.

Тайлант хугацаанд бид 8,621.0 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг дамжуулж, төлөвлөгөөг 102.0 хувиар биелүүлэн, дамжуулалтын алдагдлыг 3.52 хувьд барьж, төлөвлөснөөс 0.02 пунктээр бууруулсан нь инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлага, салбар нэгжүүдийн хамтын ажиллагааны үр дүн юм.

2025 онд том чадлын 80 МВт/200 МВт.цагийн хуримтлуурын төслийн үр ашиг бодитоор илэрч эхэлсэн нь системийн оргил ачааллыг

тэнцвэржүүлэх, импортын эрчим хүчний хамаарлыг бууруулах, сэргээгдэх эх үүсвэрийн нэвтрэлтийг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой алхам боллоо.

Монгол Улсад БНХАУ-аас ЦЭХ импортлох, Төвийн бүсийн цахилгаан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд 220 кВ-ын Зэс-Оюу дэд

станцын ил хуваарилах байгууламж болон 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг амжилттай дуусгаж, хүчдэл дор залгав. Стратегийн төслүүдийг ашиглалтад оруулснаар системийн уян хатан байдал, импортын чадвар, сэргээгдэх эх үүсвэрийн нэвтрэлтийг дэмжих бодит ахиц гаргалаа.

ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд дэд станцуудын тоноглол шинэчлэх ажил 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр эхэлж, 17 дэд станцын ажлыг бүрэн дуусгасан. Ирэх 2026 онд үлдсэн 15 дэд станцын ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажил хангагдаад байна.

Өндөр хүчдэлийн тосны химийн лабораторид MNS ISO/IEC 17025:2018 стандартыг нэвтрүүлснээр компани өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, лабораторийн шинжилгээ нь дотоодын болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх боломж бүрдсэн.

ОХУ-ын “Россети” нийгэмлэгтэй хамтран улс хоорондын агаарын шугамын ашиглалтын түвшинг сайжруулах, 220 кВ-ын 257, 258-р АШ-ын РХА-ыг шинэчлэх, Баруун бүсийн 110 кВ-ын ЦДАШ-ыг хоёр хэлхээ болгон өргөтгөх, ОХУ-ын эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллах, тогтворжилтыг хангах зорилгоор аваар эсэргүүцэх автоматикуудын ТЭЗҮ-г

хамтран боловсруулах техникийн боломжийг судлах асуудлаар ажлын хэсэг байгуулж, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах бодит төслүүдийг хамтран хэрэгжүүлэх чухал алхам боллоо.

Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд 110/35/10 кВ-ын Туул дэд станцыг түшиглэн өндрийн сургалтын төвийг нээлээ. Тус төвд “Өндөр хүчдэлийн техникч”-ийн хосмог сургалт явуулах, багш, дадлагажуулагчдын чадавхыг сайжруулах, бодит орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрэгжүүлэх, сэлгэн залгалт, өндөрт ажиллах дадлыг төлөвшүүлэх боломжтой болсон.

Санхүүгийн хувьд 671.0 тэрбум төгрөгийн орлого, 688.2 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 8.3 хувиар бууруулж чадлаа. Валютын ханшийн зөрүү болон гадаад зээлтэй холбоотой зардал компанийн үр дүнд нөлөөлсөн хэвээр байгаа боловч зардлын хяналт, зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд хэмнэлтийг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга батыг баримталлаа. Цаашид бид валютын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хурдасгах, ухаалаг сүлжээний шийдлүүдийг өргөжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд бодлогын түвшинд анхаарч ажиллана.

Эдгээр амжилтын ард хамт олны хичээл зүтгэл, мэргэжлийн ёс зүй, тасралтгүй ажиллагааг хангах чин сэтгэлийн хөдөлмөр оршиж байна. Та бүхэндээ талархал илэрхийлж, цаашдын хамтын ажиллагаанд амжилт хүсье.

Манай хамт олон 2026 онд стратегийн төлөвлөлт, санхүүгийн тогтвортой байдал, дэвшилтэт технологийн нэвтрүүлэлтийг уялдуулан компанийн урт хугацааны үнэ цэнийг тогтвортой нэмэгдүүлэхийг зорьж ажиллах болно.



Хүндэтгэсэн,
Б.ДАШДАВАА

“ЦДҮС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

I. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮР ДҮН, ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дамжуулалт, системийн найдвартай ажиллагаа

Дамжуулсан ЦЭХ: 8,621.0 сая.кВт.цаг

Төлөвлөгөөний биелэлт: 102.0%

Өмнөх оноос өсөлт: +7.4%

Дамжуулалтад авсан ЦЭХ: 8,935.6 сая.кВт.цаг

Төлөвлөгөөний биелэлт: 101.9%

Сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 6.33% байсан бол 2025 онд өмнөх оны мөн үеэс 7.3 хувь буюу 605.5 сая кВт.цагаар нэмэгдсэн нь хэрэглэгчийн тоо өсөж, системийн холболтууд нэмэгдсэнтэй холбоотой.

1.2. Нийт алдагдал

Нийт алдагдал: 314.6 сая.кВт.цаг

Алдагдлын хувь: 3.52%

Төлөвлөгөөнөөс: 0.02 пунктээр буурсан

Бүтцээр:

Техникийн алдагдал: 3.39%

Дотоод хэрэглээ: 0.14% (төлөвлөгөөнөөс 0.03%-р буурсан)

Системийн урсгал өөрчлөгдсөн (Бөөрөлжүүт ЦС 300 МВт нийлүүлэлт), импорт буурсан зэрэг нь бүсүүдийн алдагдалд нөлөөлсөн.

II. САНХҮҮГИЙН ҮР ДҮН

2.1. Орлого

Нийт орлого: 671,037.4 сая төгрөг

Төлөвлөгөө: 100.02%

Өмнөх оноос өсөлт: +20.4%

Орлогын бүтэц:

Оюу Толгой ХХК гэрээ: 514,958.4 сая төг

Үндсэн үйл ажиллагаа: 119,454.4 сая төг

Үндсэн бус үйл ажиллагаа: 36,624.6 сая төг

Оюу Толгойтой холбоотой гааль, НӨАТ-ын тооцоо: 76,017.6 сая төгрөг.

2.2. Зардал

Нийт зардал: 688,168.8 сая төгрөг

Төлөвлөгөө: 99.8%

Өмнөх оноос өсөлт: +23.0%

Зардлын бүтэц:

Оюу Толгой ХХК гэрээний зардал: 514,958.4 сая төг

Үндсэн үйл ажиллагааны зардал: 135,943.5 сая төг

Үндсэн бус зардал: 37,266.7 сая төг

241.4 сая төгрөгийн хэмнэлтийг зохион байгуулалтын арга хэмжээгээр гаргасан.

2.3. Ашиг, алдагдал

Татварын өмнөх алдагдал: -17,131.2 сая төг

Татварын дараах цэвэр алдагдал: -17,136.2 сая төг

Төлөвлөснөөс алдагдал 1,546.7 сая төг -8.3%-р буурсан.

Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал: 1.03 төг

III. САНХҮҮГИЙН БАЙДАЛ (БАЛАНС)

3.1. Нийт хөрөнгө

Нийт хөрөнгө: 930,494.1 сая төгрөг

Эргэлтийн хөрөнгө: 3.4%

Эргэлтийн бус хөрөнгө: 96.6%

Өмнөх оноос +8.4% өссөн.

Нөлөөлсөн хүчин зүйлс:

- АУС, ББС нэгтгэлээр нэмэгдсэн хөрөнгө
- Том чадлын хуримтлуур (OL3874) төсөл
- Урт хугацаат зээлийн өсөлт

3.2. Өр төлбөр

Нийт өр төлбөр: 586,930.0 сая төг (63.1%)
Урт хугацаат: 583,460.8 сая төг (62.7%)
Богино хугацаат: 3,469.2 сая төг (буурсан)

Урт хугацаат зээл: 339,852.3 сая төг
Том чадлын хуримтлуур төсөл: 307,181.8 сая төг

Валютын ханшийн зөрүү нь ашиг алдагдалд сөргөөр нөлөөлж байна.

3.3. Эздийн өмч

Эздийн өмч: 343,564.1 сая төг (36.9%)

Өмнөх оноос өсөлт: 27,613.1 сая төг

Хуримтлагдсан алдагдал нэмэгдсэн (16,916.0 сая төг)

IV. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИХ ЗАСВАР

4.1. ИЗ, ТЗБАХ, ХО

Төлөвлөгөө: 26,909.0 сая төг
Гүйцэтгэл: 12,572.9 сая төг

Биелэлт: 46.7%

Санхүүжилтийн шийдвэр оны эцэст гарч, худалдан авалт хойшилсон нь гүйцэтгэл удааширахад нөлөөлсөн.

V. ХҮНИЙ НӨӨЦ

Батлагдсан орон тоо: 1561
Ажиллаж буй: 1444
Нийт цалингийн сан: 65,761.5 сая.төг
Дундаж сарын цалин: 3,795,098 төг

Ажилтны бүтэц:

- Шуурхай үйлчилгээ: 50.6%
- Засвар: 11.4%
- Ээлжийн бус ИТА: 26.5%

- Ээлжийн бус БТА: 11.5%

VI. СТРАТЕГИЙН ТӨСЛҮҮД

6.1. Төвийн бүсийн сүлжээ шинэчлэл (KFW)

Үр нөлөө:

- 110 кВ таслуур бүрэн элегаз болно.
- 220 кВ дэд станцуудын хамгаалалт шинэчлэгдэнэ.
- “Ухаалаг сүлжээ”-ний суурь бүрдэнэ

6.2. 80 МВт / 200 МВт.цаг хуримтлуур

Үр нөлөө:

- Импорт бууруулна
- Оргил ачаалал тэнцвэржүүлнэ
- СЭХ интеграц нэмэгдүүлнэ
- Нүүрсний хэрэглээ бууруулна

Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас "Өөрчлөлтгүй" гэж дүгнэсэн.

ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

Компани 2025 онд дэвшүүлсэн 10 зорилт, 101 төлөвлөгөөт ажлыг 96.4 хувиар биелүүлж, удирдах болон дээд байгууллагын үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсэн.

Компанийн худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр 100 хувь зохион байгуулсан. Компани нь Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлагнавал зохих мэдээллийг заасан хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлж ажилласан.

“Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт (тариф)-ын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2025 оны 05 дугаар сард бүртгэн, мөрдөж эхэлсэн тул ажилтнуудын мэдлэг, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, сургалтын нөхцөлийг чанаржуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд тавих хяналтыг сайжруулах асуудлууд дээр талууд саналаа нэгтгэн 2025-2026 оны “Хамтын гэрээ”-г Захиргаа, ҮЭХ байгууллаа.

2001 онд батлагдсан технологийн картыг шинэчилж, засвар, реле хамгаалалт, холбооны ажлыг гүйцэтгэх аргачлал, тусгай зориулалтын машин механизмын ашиглалтын зааврыг боловсруулан баталж, үйл ажиллагааны аюулгүй байдал, стандартчиллыг сайжруулав.

Компанийн хэмжээнд ажлын байрны тодорхойлолтын үндсэн зорилт, сургах, мэргэшүүлэх хөтөлбөрийг чанаржуулах, ажилтны ажлын гүйцэтгэлийн түвшинг үнэлж дүгнэх зорилтын хүрээнд нийт 30 нэр төрлийн мэргэжлээр “Тариф мэргэжлийн зэргийн лавлах жишиг баримт бичиг”-ийг шинээр боловсруулан батлав.



GIZ-ийн төсөлтэй хамтран 110/35/10 кВ-ын Туул дэд станцын дэргэдэх “Өндрийн сургалтын төв” байгуулснаар дэд станцын үндсэн тоноглол, агаарын шугамын ашиглалт, засварын практик дадлага сургалтыг зохион байгуулах боломжтой болсон.



Хамтын ажиллагааны хүрээнд ШУТИС-ийн Эрчим Хүчний Инженерчлэлийн сургуулийн "Өндөр хүчдэлийн туршилт, судалгааны лаборатори"-г иж бүрэн шинэчлэн тохижуулж, 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хүлээлгэн өглөө.

Хосмог сургалтын тогтолцоог бэхжүүлэх, ажлын байрны сургагч болон чадамжийн үнэлгээний хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ахиц гаргаж, 2025 онд GIZ болон МҮХАҮТ-тай хамтран хосмог сургалтын хүрээнд “Ажлын байрны сургагч, Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш” бэлтгэх II–IV ээлжийн сургалтад нийт 48, “Чадамжийн үнэлгээний ажилтан, баталгаажуулагч” сургалтад 13, “Түгээн дэлгэрүүлэгч багш” сургалтад 14 ажилтан тус тус хамрагдсан.

Компанийн хэмжээнд 2006-2025 онд гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, зөвлөгөөнд хамрагдсан ажилтнуудын судалгааг мэргэжлийн чиглэл, зардлаар (компани, гадны байгууллагын, хувийн) ангилан хэлтэс, салбар, ажилтан тус бүрээр боловсруулан цахим мэдээллийн сан үүсгэв.

“Улсын үзлэг зохион байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан удирдамжийг үндэслэн компани архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны улсын үзлэгт хамрагдаж, 2025 оны “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ээр 94.3 буюу А үнэлгээтэй дүгнэгдэв.

2025 онд 1444 ажилтантай ажиллаж, 241 ажилтан шинээр томилогдон өөрийн хүсэлтээр 117 ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, хүний нөөцийн эргэлтийн коэффициент 8.1 хувьтай байна.





Компанийн нийт ажилтны 53 хувийг инженер техникийн ажилтан эзэлж байна. Ажилтнуудын дундаж нас 39 бөгөөд 68 хувийг 26-45 насны ажилтнууд эзэлж байна. Ажилтнуудын 70 хувь нь дээд боловсрол эзэмшиж, 12 зөвлөх, 52 мэргэшсэн инженер, нягтлан бодогч, төсөвчин байна. Компанийн нийт орон тооны 51 хувийг шуурхай ажиллагааны ажилтнууд эзэлж байна.



Нийт ажилтнуудын 68% хувийг 26-45 насны ажилтнууд эзэлж байна.

“Жендерийн эрх, тэгш байдлыг хангах ажлын хэсэг”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны

бус салбар зөвлөл”, “Эцэг эхийн зөвлөл” нь 2025 онд чиг үүргийн хүрээнд зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг, чиглэлийг бүрэн ханган ажиллав. Энэхүү үйл ажиллагаа нь компанийн засаглал, хүний эрхийн хэрэгжилт, нийгмийн хариуцлага болон оролцогч талуудын хамтын ажиллагааг бодитойгоор бэхжүүлэхэд чиглэсэн.



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ХАБЭА, дотоод хяналт мониторингийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд нь компанийн стратегийн үндсэн тулгуур зорилтууд болох найдвартай ажиллагаа, аюулгүй байдал, дижитал шилжилт, үр ашиг, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ байна.

Компанийн хэмжээнд урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг гурван шатаар зохион байгуулж, нийт 43,055 удаа үзлэг хийж, 4263 зөрчлөөс 3865 зөрчлийг арилгуулсан. Салбар, нэгжүүдэд ээлжит зааварчилга, галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгал зохион байгуулж, 3,147 нэгжид давхардсан тоогоор 16,338 удаа галын аюулгүй байдлын үзлэг шалгалт хийж, 195 зөрчлөөс 191 зөрчлийг арилгуулсан. Эдгээр арга хэмжээ нь компанийн урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, осол, гэмтлийн эрсдлийг бууруулах, ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажил болсон.

Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, шугам сүлжээ хамгаалах дүрмийн хэрэгжилтийг хангах үүднээс 220, 110 кВ-ын ЦДАШ, 80 гаруй дэд станцын 7000 гаруй км хамгаалалтын зурваст үзлэг шалгалт явуулж, айл өрх, ААН-д мэдэгдэл, албан шаардлага, зөрчлийн хэрэг үүсгэх, торгох, албан даалгавар өгөх, орон нутгийн удирдлагатай хамтран сэрэмжлүүлэг хүргүүлэх зэрэг есөн чиглэлээр арга хэмжээ авч, 2025 онд 1411 мэдэгдэх хуудсаар 21 зөрчлийг арилгуулж, 14 ААН-д улсын байцаагчийн албан шаардлага өгч, албан бичиг хүргүүлж ажилласан.

2025 оны 02 дугаар сард ЦДҮС ТӨХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцооны олон улсын ISO 45001:2018 стандартыг амжилттай авсан.


- SWOT анализаар гадаад, дотоод асуудлыг тодорхойлсон.
- Нийт дотоод 9, гадаад 21 сонирхогч талыг тодорхойлж, 3×3 матрицаар үнэлгээ хийсэн.
- 16 хууль, 12 дүрэм, 8 журам, 20 стандарт зэрэг нийт 56 эрх зүйн баримт бичгийн нийцлийн үнэлгээ хийсэн.
- OGSM төлөвлөгөөний хүрээнд 9 зорилт дэвшүүлж, 35 стратеги, 83 нэр төрлийн хэрэгжүүлэх арга зам төлөвлөсөн.
- Дотоод аудитын шалгалтад үл нийцэл илрээгүй.



ISO 45001:2018 стандарт, компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлоготой уялдуулан ажлын байр, ажил гүйцэтгэх жишиг зааварчилгааг иж бүрэн шинэчлэн батлав. Шинэчилсэн баримт бичигт ажлын байрны 23, ажил гүйцэтгэх үеийн 32 зааварчилгаа багтсан бөгөөд эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан практик хэрэглээний баримт бичиг болсон нь зааварчилгааны хэрэгжилт, чанар, ажилтны мэдлэг, ур чадварыг сайжруулах, аюулгүй ажиллагааг бэхжүүлэх суурь болсон.

Аюулгүй ажиллагааг дээшлүүлэх зорилгоор “Аюулгүй ажиллагааны зөрчилгүй ажилласан цаг” уралдаан зохион байгуулж, сар бүр аюулгүй ажиллагааны зөрчилгүй ажилласан цагийг дүгнэж, тэргүүн байранд техникийн нэгжээс Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба, техникийн бус нэгжээс Зүүн-Өмнөд бүсийн салбарын Захиргаа, аж ахуйн алба шалгарсан.

Нийт 1,120 ажилтны 76 ажлын байранд "Хэлт Инспекшин" ХХК-тай хамтран хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийж, 101 ажилтныг хүйтэн болон дулааны улиралд хэмжилт, үнэлгээнд хамруулсан. Үүнд:



Компанийн зарим нэгж, салбарын үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит зохион байгуулж, анхан шатны баримт бүрдүүлэлт, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, ажлын төсөв, худалдан авалтын гэрээ, мөнгөн хөрөнгийн хадгалалт, материал, сэлбэг хэрэгслийн бүртгэл, үлдэгдэл нөөц, орон тоо, цалин хөлсний баримт, бодолт зэргийг хянан шалгасан. Үүний үр дүнд 89 зөрчлийг илрүүлж, арилгуулах арга хэмжээ авч, давхардсан тоогоор 81 асуудлаар зөвлөмж хүргүүлэв.

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ БА БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Компани дунд болон урт хугацааны хөгжлийн чиглэлийг шинжлэх ухаанд суурилсан арга зүйгээр тодорхойлж, бодлогын нэгдмэл байдал, хэрэгжилтийн уялдаа, удирдлага, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, компанийн хөгжлийн чиг баримжааг системтэйгээр тодорхойлоход бодитой хувь нэмэр оруулах арга хэмжээ авч, дараах ажлуудыг хэрэгжүүлэв.

Техникийн бодлогын баримт бичгийн шинэчлэл

2027 болон 2035 он хүртэлх хөгжлийн түвшинг тодорхойлсон техникийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулснаар

- Дамжуулах сүлжээний хүчин чадал, найдвартай ажиллагааны шаардлагыг үе шаттай тодорхойлов;
- Хөрөнгө оруулалтын эрэмбэ, техникийн шийдлийн нэгдсэн шалгуурыг тогтоов;
- Салбарын хэмжээнд мөрдөх стандарт, төлөвлөлтийн арга зүйг нэг мөр болгож, бодлогын тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдэв.

“Сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх” төлөвлөгөө

Системийн найдвартай ажиллагаа, эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгоор 8 үндсэн чиглэл бүхий цогц төлөвлөгөөг боловсруулж, техник зохион байгуулалтын арга хэмжээг эрэмбэлэн хэрэгжүүлэх үндэс тавигдав. Энэхүү төлөвлөгөө нь:

- Системийн гэнэтийн саатал, томоохон тасалдлаас урьдчилан сэргийлэх
- Тоног төхөөрөмжийн насжилт, ачааллын өсөлттэй уялдсан эрсдэлийг бууруулах;
- Засвар үйлчилгээ, реле хамгаалалт, SCADA, кибер аюулгүй байдлын уялдаа холбоог сайжруулах бодит хөшүүрэг болж байна.
-

Гадаад хөрөнгө оруулалтын төвлөрөл

Олон улсын донор байгууллагуудтай (Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, JICA, KfW зэрэг) идэвхтэй хамтран ажиллаж, 150 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэв. Үүний үр дүнд:

- Улсын төсөвт ирэх санхүүгийн дарамт буурсан;
- Томоохон дэд бүтцийн төслүүдийг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх боломж нээгдсэн;

Төсвийн хяналт ба хэмнэлт

2025 оны их засвар, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд техник-эдийн засгийн дүн шинжилгээ хийж, зардлын оновчлолыг хэрэгжүүлснээр 1.48 тэрбум төгрөгийн бодит хэмнэлт гаргав. Энэ нь:

- Төсвийн сахилга бат, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах;

- Хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх;
- Ил тод, хариуцлагатай санхүүгийн удирдлагыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Тарифын шинэ загварчлал

Жигнэсэн дундаж хөрөнгийн өртөг (WACC) болон зохицуулах суурь хөрөнгө (RAB)-д суурилсан тарифын шинэ загварчлалыг боловсруулж, компанийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, зээлийн эргэн төлөлтийг урт хугацаанд өөрийн орлогоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх, зохицуулалтын орчны ил тод, тооцоололд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэв.

Grid Portal – Орон зайн нэгдсэн мэдээллийн сан

Дамжуулах сүлжээний 98 дэд станц, 6351 км агаарын шугам, 20,046 тулгуурын мэдээллийг байр зүйн (GIS) суурьтай нэгдсэн санд бүртгэх ажлыг гүйцэтгэж, төрийн байгууллагуудтай мэдээлэл ижил түвшинд солилцох, газар олголт, хамгаалалтын бүсийн зөрчлийг бууруулах, төлөвлөлт, трасс сонголт, хүчин чадлын тооцоог орон зайн анализад суурилан гүйцэтгэх нөхцөл бүрдэв. Энэхүү систем нь компанийн стратегийн төлөвлөлтийг өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтад шилжүүлэх чухал алхам боллоо.

Zenon SCADA системийн хөгжүүлэлт

SCADA системийн архитектурыг сайжруулж, өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэн 26 дэд станцыг алсаас хянах, өгөгдөл бүртгэх, архивлах, дүн шинжилгээ хийх боломжийг нээв. Үүний үр дүнд диспетчерийн ажиллагааны шуурхай байдал нэмэгдэж, горимын тооцоо, алдагдлын үнэлгээ, ачааллын шинжилгээний нарийвчлал сайжирч, системийн үйл ажиллагаанд ил тод, бодит цагийн хяналт бий болов.

Норм, стандартын шинэчлэл

Компанийн техникийн түвшинг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор 5 стандартыг боловсруулж, үүнээс MNS ASTM D924 (Цахилгаан тусгаарлах зориулалттай шингэний диалектрикийн алдагдал болон харьцангуй диалектрикийн нэвчилтийг тодорхойлох туршилтын арга) болон MNS IEC 60156 (Тусгаарлагч шингэн тэжээлийн давтамж дахь нэвт цохилтын хүчдэлийг тодорхойлох. Сорилтын арга) стандартыг үндэсний стандарт (MNS) болгон батлуулсан нь

- Туршилт, хэмжилтийн аргачлалын нарийвчлалыг сайжруулах;
- Техникийн шийдвэр гаргалтын нэг мөр байдлыг хангах;
- Салбарын хэмжээнд нэгдсэн, баталгаатай норм, стандартын орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.

ТЕХНИКИЙН БОДЛОГО

Системийн ачааллын өсөлт, тоноглолын насжилт, техникийн хүчин чадлын хязгаарлалт зэрэг сорилтууд нэмэгдэж байгаа нөхцөлд судалгаа, тооцоонд тулгуурласан шийдвэр гаргах, дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг хангах, горим төлөвлөлтийг боловсронгуй болгох, техникийн нөхцөлийг тооцоо судалгаанд тулгуурлан шийдвэрлэх, эрчим хүчний хэмнэлтийг бодит үр дүнтэй хэрэгжүүлэх, барилга угсралт, зураг төсөлд хяналт тавих чиглэлээр техникийн бодлогыг хэрэгжүүлж ажилласан.

Горим ажиллагаа, найдвартай байдал

- Компанийн хэмжээнд тулгамдсан болон төлөвлөгөөт 33 асуудлыг Үйлдвэрлэл-техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн.
- 2024–2025 оны өвөл, 2025 оны зун, 2025–2026 оны өвлийн горим ажиллагааг боловсруулж мөрдүүлсэн.
- Зуны болон өвлийн их, бага ачааллын хяналт хэмжилтийг зохион байгуулж, тайлан нэгтгэсэн.
- 2025 онд системийн оргил ачаалал 1743 МВт хүрч, хэрэглээ өмнөх оноос 70–90 МВт-аар өссөн.
- 220 кВ, 110 кВ-ын шугам, тоноглолын тасралт, таслалтын судалгааг өмнөх онтой харьцуулан гаргаж, ЭХЗХ-д хүргүүлсэн.
- Насжилт өндөртэй шугамуудад (Хархорин А, Б; Чойр–Бор-Өндөр) уур амьсгалын нөлөөлөл, тулгуурын тооцооны судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн.

Эрчим хүчний хэмнэлт

- 44 нэр төрлийн арга хэмжээнд 2.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 98.9%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.
- Нийт 422.7 мян.кВт.цаг цахилгаан эрчим хүч хэмнэж, CO₂ ялгаруулалт 317.0 тонноор бууруулсан.
- “Үүрэг хүлээсэн хэрэглэгч”-ийн үнэлгээгээр 97% буюу “Хангалттай сайн” үнэлгээ авсан.
- Улаанбаатар салбарын шинэ оффист 570Вт-ын 32 нарны хавтан, 4 батерей суурилуулж 17,660 кВт.цаг эрчим хүч нийлүүлсэн.
- 8 дэд станцын дулаан алдалтыг бууруулахад кабель битүүмжлэх засварын ажил хийгдсэн

Техникийн нөхцөл, төсөл хяналт

- 2025 онд 434 техникийн нөхцөлийн хүсэлт судалж, 168 хүсэлтийг дэмжиж, 266 хүсэлтэд боломжгүй хариу өгсөн.
- 1300 МВт-ын нүүрсний 8 ДЦС, 395.4 МВт-ын 6 СЭХ эх үүсвэрийн техникийн нөхцөл баталгаажсан.
- 89 зураг төслийг судалж, зөвшилцөн хяналт тавьсан.
- 2025 оны их засвар, ТЗБАХ-ийн хүрээнд 15 ажлын зураг боловсруулж батлуулсан.

Барилга байгууламж

- Компанийн барилга байгууламжийн мэдээллийг Эрчим хүчний нэгдсэн мэдээллийн санд бүртгэж, “Барилга байгууламжийн ашиглалтын заавар”-ыг батлуулсан.
- Оюу Толгойн 220 кВ-ын ИХБ-ын барилга угсралтын ажилд 6 удаагийн хяналт хийсэн.
- Улсын болон орон нутгийн төсвөөр хэрэгжиж буй барилга угсралтын ажлуудад норм, дүрмийн дагуу хяналт тавьсан.

Бүсийн нэгтгэл, стратегийн төслүүд

- Засгийн газрын 30 дугаар тогтоолын хүрээнд ББЭХС, АУЭХС-ийг нэгтгэх ажлын хүрээнд салбаруудад ажиллаж, хөрөнгийн шилжилт, баримт бичгийн хүлээлцлийг зохион байгуулсан.
- “Эгийн голын УЦС” төслийн шугам, дэд станцын байршлын судалгаанд оролцож, холбогдох байгууллагуудтай хамтран газар дээр нь ажилласан.

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлж, 30 дэд станцын шинэчлэлийн зураг төслийг боловсруулан магадлалаар баталгаажуулж, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт болон татварын чөлөөлөлтийг шийдвэрлэн барилга угсралтын бэлтгэлийг бүрэн хангав. 2025 онд 17 дэд станцад тоноглол шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, системийг өвлийн горимд найдвартай шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд 2026 онд үлдсэн 15 дэд станцын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх бэлтгэл хангагдсан байна.

ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТ

ЦДҮС ТӨХК-ийн 220/110/35/10/6 кВ-н 98 дэд станц, 220/110/35 кВ шугам, тоноглолын тасралтгүй найдвартай ажиллагааг ханган, өдөр тутмын горим ажиллагаанд тогтмол хяналт тавьж, зохицуулалт хийж, шуурхай ажиллагааны хүмүүсийг нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан.

Компанийн хэмжээнд ТЗБАХ, ИЗА, KFW төсөл, Алтанбулаг "Чөлөөт бүс" төсөл, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт зэрэг төслийн ажлаар шинээр 220 кВ-н АШ 2, 110 кВ-н АШ 5, гадны байгууллагын 2 дэд станц, манай эзэмшлийн 2 станц, 35 кВ-н АШ 14, 10/6 кВ-н нийт 22 гаргалгаа, Сүхбаатар д/ст-н бүрэн шинэчлэл, Налайх, Баянчандмань, Хялганат, Төв, Хот, Айраг, Баруунхараа, Баясгалант, Сүхбаатар, Хөтөл, Шарынгол, Бугант, Үйлдвэр, Орхон, Булган, Хархорин, Бор-Өндөр, Зүүнхараа, Багануур, Улаанбаатар, Чойр, Дархан д/ст-н KFW төслийн шинэчлэл, Зэс Оюу ИХБ-н 220 кВ I, II СШ, 220 кВ-н ТойСШ-н бүх тоноглолыг хүчдэл дор залгаж, хэвийн схем горим ажиллагаанд оруулсан.

253, 254-р АШ, Зэс-Оюу д/ст 220 кВ-н I, II СШ, ТойСШ-н бүх тоноглолын анхдагч болон хоёрдогч хэлхээний ажил дуусаж, 253,254-р АШ, Зэс-Оюу д/ст 220 кВ-н I,II СШ, ТойСШ-н бүх тоноглолыг хүчдэл дор залгах 10 хэсгээс бүрдсэн 322 үйлдэлтэй сэлгэн залгалтын үлгэрчилсэн программыг батлуулж, амжилттай хийж гүйцэтгэсэн.

KFW төслийн хүрээнд "32" дэд станцын шинэчлэл хийхээс 17 дэд станцын ажил бүрэн дуусаж, 5 дэд станцын шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлж, 10 дэд станцын ажлыг 2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. KFW төслийн ажлын хүрээнд 186 тоноглолыг шинээр сольж, суурилуулж, хүчдэл дор залгах сэлгэн залгалтын программыг боловсруулж, амжилттай хийж гүйцэтгэсэн.

Эрдэнэнар НЦС-ын 20/80 МВт/МВт*цаг батарей хуримтлуурын станцыг Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс бүрэн тусгаарлаж, black start, grid forming функц ашиглан Замын-Үүд дэд станцын хэрэглээг тэжээх туршилтын ажлыг Солар Повер Монголиа ХХК болон ДҮТ ТӨХХК-тай хамтарч амжилттай зохион байгуулж, хэрэглэгчийг эрчим хүчээр удаан хугацаанд хязгаарлах эрсдэлийг бууруулсан. Энэ нь Монгол улсын хэмжээнд Нарны цахилгаан станц болон батарей хуримтлуурын станц нэгдсэн сүлжээнээс тусдаа гарч, хослон ажиллаж, хүчдэл болон давтамжийн тохируулгыг тогтвортой барьж, нийт 18 цагийн турш 5.4 МВт хэрэглээг хангаж ажилласан анхны тохиолдол байлаа. Улмаар 110 кВ-ын Айраг, Сайншанд, 143-р АШ-ын урсгал засварын ажлын үед дээрх схемийн шийдлээр Замын-Үүд дэд станцын хэрэглээг тэжээж, хэрэглэгчийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж ажилласан.

110/35/10 кВ-н Айраг дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд 110 кВ-ын секц холбогч таслуур Айраг болон Сайншанд АШ-ын таслуурыг хослон гүйцэтгэдэг байсан схемийн шийдлийг өөрчилж, систем шин суурилуулж, жонш боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн тэжээл болох 110 кВ-ын Овоот АШ-ын тоноглол суурилуулсан. Энэхүү ажлын хүрээнд томоохон схемийн өөрчлөлт хийж, Айраг дэд станцад 110 кВ-н Айраг АШ-н төгсгөлийн анкер болон 110 кВ-ын Сайншанд, Овоот АШ-н эхлэлийн анкер тулгуурын хооронд шууд холболт хийж нэгтгэн Т-2-г тэжээж ажиллах үедээ 110 кВ-ын систем шинийн портал, дамжуулагч, 110 кВ-ын Айраг, Овоот АШ, Т-1-н 110 кВ-ын тоноглолыг шинээр болон шилжүүлэн суурилуулж, техникийн комиссын шийдвэрийн дагуу туршилтын хүчдэлд амжилттай залгаж, Т-2-н ачааллыг Т-1-д шилжүүлсэн. Ингэснээр 110 кВ-ын

Сайншанд АШ болон Т-2-н 110 кВ-ын тоноглолыг суурилуулах ажлын байрыг бэлтгэх боломжит нөхцөлийг бүрдүүлсэн.

Компанийн хэмжээнд 3917 ажлын захиалгыг хүлээн авч, диспетчерийн болон горимын зохицуулалт хийж ажилласнаас ДҮТ-ийн удирдлага, мэдлийн тоноглолтой холбоотой 1020, компанийн болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн удирдлага мэдлийн тоноглолтой холбоотой 2897 захиалга байна.

Компанийн хэмжээнд 2025 онд 8,765.9 сая.кВт.цаг ЦЭХ эх үүсвэрүүдээс хүлээн авах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 8,935.6 сая.кВт.цаг ЦЭХ хүлээн авч, биелэлт 101.9%-тай ба 8,455.3 сая.кВт.цаг ЦЭХ түгээхүүдэд нийлүүлэх төлөвлөгөөтэй байснаас 8,621.0 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулж төлөвлөгөөний биелэлт 101.96 %-ийн гүйцэтгэлтэй байна.

№	Үзүүлэлт 2024 оны гүйцэтгэл	2025 он /сая.кВт.цаг/			Хувь	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Дамжуулах ЦЭХ	8,330.1	8,765.9	8,935.6	101.9%	
	Үүнээс: Импорт	1,088.3	887.4	717.3	80.8%	
2	Дамжуулалтын алдагдал	биетээр	305.4	310.5	314.6	101.3%
		хувиар	3.67%	3.54%	3.52%	0.0%
	Техникийн алдагдал	биетээр	293.1	296.2	302.5	102.1%
		хувиар	3.52%	3.38%	3.39%	0.0%
	Дотоод хэрэгцээ	биетээр	12.2	14.3	12.1	84.6%
		хувиар	0.15%	0.16%	0.14%	0.0%
3	Дамжуулсан ЦЭХ	8,024.8	8,455.3	8,621.0	102.0%	
	Үүнээс: Экспорт	10.4	11.4	14.1	123.9%	
4	Оюутолгойн импорт	1,453.0	1,407.9	1,603.9	113.9%	

Компанийн хүлээн авсан ЦЭХ-ийг 2024 оны дүнтэй харьцуулахад 7.23%-ийн өсөлттэй гарсан байна. Сүүлийн жилүүдийн хамгийн бага ЦЭХ-ний өсөлт 2020 онд 1.29%-тай, хамгийн их ЦЭХ-ний өсөлт 2021 онд 14.29%-тай байна. 2015-2025 оны ЦЭХ-ний дундаж өсөлт тооцооллоор 6.33%-тай гарч байна.

Дамжуулалтын нийт алдагдалд 310.5 сая.кВт.цаг буюу 3.54%-ийг зарцуулахаас 314.6 сая.кВт.цаг буюу 3.52%-ийг зарцуулсан байна.


Техникийн алдагдалд 296.2 сая.кВт.цаг буюу дамжуулалтын 3.38%-ийг зарцуулахаас 302.5 сая.кВт.цаг буюу 3.39 %-ийг зарцуулсан байна.

Дотоод хэрэгцээнд 14.3 сая.кВт.цаг буюу 0.16%-ийг зарцуулахаас 12.1 сая.кВт.цаг буюу 0.14% ЦЭХ зарцуулж, 2,2 сая.кВт.цаг ЦЭХ-ээр буурсан үзүүлэлттэй байна.


Компани 2025 онд нийт 8,935.6 сая.кВт.цаг ЦЭХ-ийг үйлдвэрлэх ТЗЭ нараас худалдан авч 8,621.0 сая.кВт.цаг ЦЭХ-ийг дамжуулсан. Дамжуулсан ЦЭХ нь 2024 онтой харьцуулахад 7.4%-р өссөн үзүүлэлттэй байна.

Төлөвлөгөөтэй харьцуулахад техникийн алдагдал 0.01%-р өссөн байна. УБС-ын техникийн алдагдал төлөвлөгөөнөөс 0.16%-р өссөн. Энэ нь Бөөрөлжүүт ЦС -ийн үйлдвэрлэл нэмэгдэж 300 МВт-г системд нийлүүлснээр 205,206-р АШ-н чадлын урсгал өөрчлөгдөж алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байна. Бусад салбарын техникийн алдагдал төлөвлөгөөнөөс буурсан.

Дотоод хэрэгцээнд төлөвлөгөөнөөс 2.2 сая.кВт.цаг ЦЭХ-ийг хэмнэсэн. Энэ нь дамжуулах компанийн үр ашиг дээшлүүлэх KFW төслийн хүрээнд нийт 22 дэд станцад 18 ш 110 кВ-н тосон таслуурыг ЭТ-р сольж, 48 ш 35 кВ-н тосон таслуурыг ЭТ-р сольсноор тоноглолын халаагуурын хэрэглээ буурахад нөлөөлсөн. Мөн дотоод хэрэгцээг хэмнэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байгаа нь дотоод хэрэгцээний хэрэглээг буурахад нөлөөлж байна.



Нийт сэлгэн залгалтын тоог U-н түвшингээр ангилбал



2025 онд 220/110/35/10/6 кВ–н нийт 710 тасралт гарснаас 1,661.4 мян.кВт.цаг ЦЭХ-ийг дутуу түгээсэн. Өмнөх онтой харьцуулахад тасралтын тоо 19.9%-иар буурсан боловч дутуу түгээсэн ЦЭХ-ий хэмжээ 43.8 хувиар өссөн. ЦЭХ дутуу түгээхэд тоноглолын хуучралт, байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлсөн.

2025 онд нийт 2015 таслалт хийгдсэнээс 7.3 сая кВт.цаг ЦЭХ-ийг дутуу түгээсэн байна. УЗА, ИЗА хүрээнд нийт таслалтын 26.5 %-г, шинэчлэлийн ажлаар 11%-г, гэмтэл устгах ажлаар 17.5%, гадны байгууллагын захиалгаар 10.4% тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад таслалтын тоо 7.6 %-р өссөн байна.

2025 оны 2,12-р саруудад 5 салбарын бүх дэд станцын тоноглол, АШ-н холболтууд дээр төлөвлөгөөний дагуу, 04,08 сард УБС-т хэсэгчилсэн халалт шалгах хэмжилтүүд хийгдсэн. FLIR маркийн шинэ багаж, VarioCAM маркын хуучин багажуудаар хэмжилт хийж Flir thermal studio программаар халалттай тоноглолын тайлан гаргаж хяналт тавьж ажилласан. Хэмжилтийн үр дүнд нийт 16 дэд станцад 36 гэмтлийг илрүүлж гэмтлийг 100% устгасан. Манай компанийн ашиглаж байгаа нийт тоноглол, АШ-уудын 50-60 % нь 30-с дээш жил ажилласан насжилт өндөртэй. Мөн өвлийн оргил ачааллын үед ачаалал ихтэй байдгаас болж тоноглолын холболтууд дээр халалт нэмэгдэж гэмтэх, аваар саатал гарах өндөр магадлалтай байдаг. Иймд тус багажаар тогтмол хэмжилт хийж, тоноглолын халалтыг шалгаж илрүүлснээр тасралт, аваар саатлын үед гарч болох гэмтэл, учирч болох эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой ажил болсон.


РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИК, ХЭМЖИЛТ ТУРШИЛТ

Реле хамгаалалт, автоматжуулалт, өндөр хүчдэлийн туршилт хэмжилт, тоолуур, хэмжүүр болон тавил тооцоо, оношилгоо диагностикийн чиглэлээр баримтлах бодлогыг тодорхойлж, реле хамгаалалт автоматжуулалт, автомат удирдлагын системийг нэвтрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, РХАБ, хэмжүүр тоолууруудын хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Системийн горимын тооцооны бодит байдлыг дээшлүүлэх, хамгаалалтын тавилын найдвартай ажиллагааг сайжруулах, дамжуулах системийн тогтвортой ажиллагааг хангах зорилгоор Реле хамгаалалт, автоматикийн бодлогын баримт бичгийг сайжруулж, ИЗА, УЗА, ТЗБАХ ажлуудад бүрэн хяналт тавьж, техникийн шаардлагын мөрдөлтийг ханган ажилласан.



Селектив бус ажиллагаа



Өндөр хүчдэлийн туршилт

Аяндын улирлын бэлтгэл хангах зорилгоор хэт хүчдэлийн хамгаалалт болон газардуулах байгууламжид хэмжилт, туршилт хийх ажлын хүрээнд дэд станцуудын цэнэг шавхагчийн тоолуурын заалтыг авч, өмнөх оныхтой харьцуулж, 5-аас доошгүй удаа ажилласан цэнэг шавхагчид хэмжилт, туршилт хийж баталгаажуулах, гэмтэлтэй цэнэг шавхагчийг солих ажлыг зохион байгуулж, нийт 220 кВ-ын 18 ш, 110 кВ-ын 240 ш, 35 кВ-ын 175 ш, 10 кВ-ын 45 ш, 6 кВ-н 148 ш цэнэг шавхагчид хэмжилт, туршилт хийж, баталгаажуулсан. Түүнчлэн ХБС-д 6 ш, ЗӨБС-д 14 ш цэнэг шавхагчийн тоолуур, ТБС-н Баясгалант дэд станцын Т-1-н 35 кВ-ын 3 цэнэг шавхагчийг сольсон.

ЦДАШ-ын тулгуурын эсэргүүцэл хэмжих, мөн газардуулгын хүрээний эсэргүүцэл норм хэмжээнд нь оруулах шаардлагыг харгалзан нэмэлт газардуулга хийх, гагнаас холбоосыг сайжруулах ажлын хүрээнд нийт 1811 буюу ТБС-н 220 кВ-ын ЦДАШ-н 204, 110 кВ-ын ЦДАШ-н 721, УБС-н 220 кВ-ын ЦДАШ-н 10, 110 кВ-ын ЦДАШ-н 35, 35 кВ-ын 5, ГБС-н 220 кВ-ын ЦДАШ-н 836 буюу нийт 220 кВ-ын ЦДАШ 1050, 110 кВ-ын 756, 35 кВ-ын 5 тулгуурын газардуулгын эсэргүүцэлд хэмжилт хийсэн болно.

ЗӨБС-н 220 кВ-ын 1 /Багануур/, 110 кВ-ын 1 /Өндөрхаан/, ТБС-н 220 кВ-ын 1 /Дархан/, 110 кВ-ын 5 /Бурхант, Үйлдвэр, Хөтөл, Толгойт, ХХБ-110/, ГБС-н 220 кВ-ын 3 /Оюутолгой, Тавантолгой, Мандал/, 110 кВ-ын 1 /Даланзадгад/ дэд станцуудын газардуулгын эсэргүүцэл хэмжихэд норм хангасан байна. ЗӨБС-н 110 кВ-ын 1 /Хот/, УБС-н 220 кВ-ын 1 /Сонгино/, 110 кВ-ын 2 /Зайсан, Дүнжингарав/ дэд станцуудад хэмжилт хийхэд норм хангаагүй байна.

Шинээр авсан багаж болох БНХАУ-ын Megger China Company Limited ХХК-иас хэсэгчилсэн цахилалт тодорхойлох ICMmonitor Portable, FRAX-101 зөөврийн багажийн практик сургалтанд хамрагдаж, компанийн үндсэн тоноглолуудад насжилтын болон төлөв байдлын судалгаат хэмжилтүүдийг хийж мэдээллийн санг баяжуулав. Үүнд 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын Т-1, Т-2, 110/35/10 кВ-ын Ташгай дэд станцын 110 кВ-ын хийн хуваарилах байгууламжын 2-р секцийн ХТ-2 т хэмжилт хийсэн.

Цахилгаан хэмжлийн лаборатори

Цахилгаан хэмжлийн лаборатори нь итгэмжлэлийн MNS-17025 стандартын шаардлага хангасан тул итгэмжлэгдсэн лабораторид Итгэмжлэлийн үндэсний төвөөс аудит ажиллаж, Монгол Улсын томилогдсон лаборатори болох ажлын хүрээнд заавар зөвлөмж өгсний дагуу бэлтгэл ажлыг хангаж ажиллаа.

Компанийн хэмжүүрийн трансформаторуудын баталгаажуулалтыг хийж, холбогдох акт, протокол, үнэт цаас гэрчилгээг олгов.

Тоолуурын нэгдсэн сүлжээний ажиллагаанд хяналт тавин үл тохиролтой тоолууруудыг шинэчлэн солих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллаа. Мөн компанийн бие даасан тоолуурын сүлжээ үүсгэх ажилтай холбогдуулан RTU325 төхөөрөмжийн ажиллагааг найдваржуулан ТНС-ний программ хангамжинд нэмэлт тохируулгыг хийж гүйцэтгэсэн.

РХА-ийн тавил тооцоо

ЦДАШ-ын эсэргүүцлийг ОМИКРОН багажаар хэмжиж, бодит параметруудийн хэмжилтийн мэдээллийн сан бүрдүүлэх, хэмжилтээр гарсан үр дүнг тооцооны үр дүнтэй харьцуулах, гэмтэлтэй цэгийн байршлыг зөв тогтоох ажлыг хэрэгжүүлэв. Хэмжилтийн утгуудын үнэн, зөв параметр нь реле хамгаалалт болон автоматикийн байгууламжийн ажиллагааг нарийвчлах, найдваржуулах, сонгох чадварыг хангахад гол үүргийг гүйцэтгэж байна.

Мөн ОХУ-д реле хамгаалалт, автоматикийн тавил тооцооны сургалтад зарим ИТА нарыг хамруулж, ДҮТ ТӨХХК-аас тооцооны программын эрх авч, хяналтын тооцоог хийж эхлүүлээд байна.

Аккумуляторын батарей зай тэжээл, шулуутгагч төхөөрөмж

Тогтмол гүйдлийн үүсгүүр болон аккумуляторын батарейн байгууламжийг шинэчлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, үе шаттайгаар сайжруулан хэрэгжүүлэх төлөвлөгөөг компанийн ҮТЗ-ийн хурлаар хэлэлцэн батлав. Мөн УБС, ХБС-ийн дэд станцуудын оператив тэжээлийн их засварын ажлын хүрээнд зарим дэд станцыг нэгдсэн сүлжээнд холбох техникийн боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Түүнчлэн салбарын дэд станцуудын батарейн байгууламжийн багтаамжийг хэмжиж, техникийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг гүйцэтгэв.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Компанийн хэмжээнд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны олон улсын ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлж, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд байгууллагын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, шаардлагатай бодлого, журам, хяналтын арга хэмжээг тодорхойлон боловсруулсан бөгөөд ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулж, мэдлэг ойлголтыг дээшлүүлээд байна. Цаашид 2026 онд олон улсын баталгаажуулалтын аудитад хамрагдан, ISO/IEC 27001 стандартын гэрчилгээг авах зорилт тавин ажиллаж байна.

Компанийн хэмжээнд Microsoft 365 системийг Standard багцаар нэвтрүүлэх зардлыг 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлсэн. Уг системийг нэвтрүүлснээр байгууллагын мэдээллийн технологийн хэрэглээг нэг стандартад оруулж, программ хангамжийн хууль ёсны байдал, аюулгүй байдал, зардлын үр ашгийг зэрэг хангах цогц шийдэл бүрдсэн.

Үүнд:

- Microsoft Office программуудыг албан ёсны лицензтэй ашиглаж, хууль бус (crack) хувилбар хэрэглэх эрсдэлийг бүрэн зогсоосон.
- Office программуудыг cloud болон desktop хосолсон хэлбэрээр ашиглах боломж бүрдэж, ажилтнууд хүссэн газраасаа аюулгүй, тасралтгүй ажиллах нөхцөл бүрдсэн.
- Microsoft Windows үйлдлийн системийг албан ёсны лицензтэй ашиглах болсноор мэдээллийн аюулгүй байдал, системийн найдвартай ажиллагаа сайжирсан.
- Microsoft Teams программыг байгууллагын албан ёсны харилцаа, хурал зөвлөгөөний нэгдсэн платформ болгон ашиглаж эхэлснээр бусад хурлын программын хэрэглээнээс татгалзаж, давхардсан лицензийн зардлыг бууруулах боломж бүрдсэн.
- Хэрэглэгч бүр 1ТВ хэмжээтэй үүлэн хадгалах багтаамжтай болсноор биет хард диск, флаш диск ашиглах хэрэгцээ буурч, файлыг төвлөрсөн байдлаар хадгалах, хаанаас ч аюулгүй хандах нөхцөл бүрдсэн.


Ингэснээр компанийн дотоод үйл ажиллагаа илүү уялдаатай, аюулгүй, зардлын хувьд үр ашигтай болох суурь орчин бүрдсэн.

Компанийн дата менежментийн систем (Dashboard)-ийг сайжруулж, боловсронгуй болгон байгууллагад ашиглагдаж буй бусад системүүдтэй өгөгдлийн сангийн (баазын) түвшинд интеграцчилал хийж, мэдээллийн урсгалыг нэгтгэсэн. Уг сайжруулалтын үр дүнд өмнөх хувилбарт гар ажиллагаагаар хийгддэг байсан тооцоолол, нэгтгэл, тайлагналын процессуудыг автоматжуулж, мэдээллийг бодит цагийн горимоор татан боловсруулах боломж бүрдсэн. Ингэснээр ажлын гүйцэтгэлийн хугацаа богиносж, хүний хүчин зүйлээс шалтгаалсан алдаа, зөрчлийг бууруулан, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг дээшлүүлсэн.

Байр зүйн мэдээллийн систем болон “Гайхам” GPS системүүдтэй өгөгдлийн түвшинд интеграцчилал хийж, мэдээллийг бодит цагийн горимоор хянах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр тоног төхөөрөмж, объект, хөдөлгөөнт нэгжийн байршил,

төлөв байдлын мэдээллийг шуурхай авах, хяналт-шинжилгээ хийх, шийдвэр гаргалтыг мэдээлэлд суурилсан байдлаар хэрэгжүүлэх нөхцөл сайжирсан.

Дамжуулах сүлжээний найдвартай ажиллагаа, шуурхай удирдлага, мэдээллийн ил тод байдал, техник технологийн хяналтын түвшин бодитоор сайжруулах чиглэлээр УБС-ийн бүх дэд станцыг СКАДА системд бүрэн холбож, хяналт удирдлагын нэгдсэн орчин бүрдүүлэн, илэрсэн үл тохирол, техникийн зөрчлийг арилгаж, УБС, ГБС, ТБС, ХБС, ЗӨБС-ийн төвүүдийг технологийн сүлжээнд холбож, салбарын ерөнхий инженерүүд СКАДА системээр дамжуулан дэд станцуудын горим, ажиллагааг төвлөрсөн байдлаар хянах боломжийг бүрдүүлсэн.



Орон нутгийн дэд станцуудыг компанийн нэгдсэн холбооны сүлжээнд үе шаттайгаар холбож, суурь сүлжээ байгуулах ажлыг компанийн хэмжээнд хэрэгжүүлсний үр дүнд нийт 72 дэд станц суурь сүлжээнд холбогдсон. Ингэснээр шаардлагатай станцуудыг СКАДА буюу технологийн сүлжээнд холбох техникийн боломж бүрдсэн. Мөн компанийн хэмжээнд бүх дэд станц, салбар нэгжүүдийг байгууллагын өөрийн SIP технологид суурилсан холбооны шийдлээр холбож, дотоод харилцаа холбооны найдвартай, тасралтгүй, аюулгүй нэгдсэн орчин бүрдүүлсэн.

Компанийн хэмжээний халдлага илрүүлэх, эсэргүүцэх системүүдэд тогтмол шинэчлэлт, өөрчлөлт хийж, салбар хоорондын сүлжээний уялдаа, тохиргоог үргэлж сайжруулж байна. Үүнтэй холбоотойгоор халдлага илрүүлэх системийн log болон report-уудыг авч, анализ хийсэн ба **FortiAnalyzer 150G** төхөөрөмжид бүх report хадгалагдах болсон бөгөөд **SolarWinds** систем рүү төхөөрөмжүүдийн мэдээллийг татаж, тохируулга хийсэн.

Шилэн кабелийн сүлжээнд холбогдсон дэд станцуудад шинээр суурилуулсан **FortiSwitch** рүү сүлжээний хэрэглээг шилжүүлэх ажлын график боловсруулж батлуулсны дагуу 28 дэд станцад ажил гүйцэтгэсэн. Үүнд UTP кабелийг сүлжээний рагнаас компьютер, SIP холбоо, цаг бүртгэл, Wi-Fi төхөөрөмж рүү татаж, станцын болон SIP холбоо, цаг бүртгэлийн төхөөрөмжийн IP хаягийг нэг стандартад оруулах, компьютерийн нэршлийг шинэчлэх, бүх төхөөрөмжийн MAC хаягийг бүртгэх, мөн биржжүүлэлт хийх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн.

Компанийн хэмжээнд ашиглагдаж буй **PowerFactory 2023 Preview** хувилбарыг шинэчилж, **PowerFactory 2023 SP4** хувилбар руу амжилттай шилжүүлсэн.

ЗАСВАР ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаа тооцоо диагностик оношилгоог үндэслэн тоноглолын засварыг оновчтой төлөвлөж зохион байгуулах, чанар, биелэлтэд хяналт тавих шинэ дэвшилтэд техник технологи, арга барилыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд их засварын 121, ТЗБАХ-ний 35, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 44 буюу нийт 200 нэр төрлийн ажил бүрэн дууссан.

Тайлант хугацаанд ИЗА болон ТЗБАХ-ийн ажлын хүрээнд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт ажлуудаас:

- Улаанбаатар салбарын 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 40 МВА хүчин чадалтай Т-1 трансформаторыг бүрэн засварлаж, трансформатор засварын цехээс Буянт-Ухаа дэд станцад тээвэрлэн суурилуулав.
- 110/35 кВ-ын ИХБ-3-ын Т-1 трансформаторын их засварын ажил
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-1, Т-2 трансформаторуудын их засварын ажил
- 110/10 кВ-ын Хөшигт дэд станцын газардуулгын эсэргүүцэл бууруулах ажил
- 110 кВ-н Хялганат-Б ЦДАШ –ын дундын тулгуурт тусгаарлагч элемент солих ажил
- Тоноглолын аюулгүй нөөц бүрдүүлэх ажил

Төлөвлөгөөт бус ажил

- 110/10/6 кВ-н Өмнөд дэд станцын 25 МВА хүчин чадалтай Т-2 трансформаторт хэмжилт, туршилт буюу идэвхит хэсэгт өндөр хүчдэлийн бүрэн хэмжилт, трансформаторын тосонд хийн хроматографийн шинжилгээ хийсэн.
- Зүүн-Өмнөд бүсийн салбарын 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцын 25МВА чадалтай Т-1 трансформаторын гэмтлийг устгаж буцаан сүлжээнд залгасан.

ISO/IEC 17025:2018 — Тосны Химийн Лаборатори

Өндөр хүчдэлийн тосны химийн лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага хангасан тул Үндэсний итгэмжлэлийн төвөөс 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр гэрчилгээ гардан авсан. Ингэснээр зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэж, лабораторийн шинжилгээний үр дүн нь дотоод болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой болсон.

2025 онд нийт 214 удаагийн тосонд ууссан хийн хроматографийн, 16 удаагийн зуурамтгай чанар тодорхойлох, 8 удаагийн тангенс, дельта тодорхойлох, 217 удаа цахилгаан даац тодорхойлох, 186 удаагийн усны агуулга тодорхойлох шинжилгээнүүдийг гүйцэтгэж ажилласан байна. Компанийн үйл ажиллагаанд ашиглаж буй цахилгаан тоноглолын тусгаарлах тосны чанарыг тодорхойлох, тоноглолын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, гэмтлийг оношилох зорилго бүхий тосны химийн лабораторид нийт 625 удаагийн шинжилгээ хийж баталгаажуулсан.

220 кВ-ын “Зэс Оюу” хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил

Улсын хэмжээнд өндөр хүчдэлийн дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, барилга угсралтын тусгай зөвшөөрөл бүхий тул 220 кВ-ын “Зэс-Оюу” хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ЦДҮС ТӨХК сонгогдож, “Оюутолгой” ХХК-тай 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр гэрээ байгуулсан.

Төслийн талбайн барилга угсралтын бэлтгэл ажлыг хангаж, 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр анхдагч хэлхээний тоноглолын угсралтын ажлыг эхлүүлсэн. Үргэлжлүүлэн 2025 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хоёрдогч хэлхээ болон холбоо, мэдээллийн системийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, төлөвлөгөөний дагуу бүрэн гүйцэтгэсэн. Барилга угсралтын ажил дууссаны дараа Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан техникийн комисс 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ажиллаж, хуваарилах байгууламжийн тоноглолыг 72 цагийн турш хүчдэл дор туршин шалгаж, ашиглалтад хүлээн авсан. 220 кВ-ын “Зэс-Оюу” хуваарилах байгууламжийн иж бүрэн барилга угсралтын ажлыг 250 ИТА, 40 нэгж, хүнд машин механизмын оролцоотойгоор 265,000 хүн-цагийн хөдөлмөр зарцуулан амжилттай гүйцэтгэсэн.

ПХБ (Полихлорт Бифенил)-ийн төсөл

Хорт бодис ПХБ-ийн агууламжийг стандарт хэмжээнд хүргэх, трансформаторын хөндийрүүлэг дээшлүүлэх зорилготой тус төсөл 2025 онд идэвхтэй үргэлжилж, 57 тонн тосыг цэвэрлэсэн.

2025 онд ПХБ цэвэрлэлт хийгдсэн дэд станцууд:

- УБС-ын 110/35/6 кВ-ын ИХБ-3 дэд станц (SFSZ-11 40000/115, 40МВа)
- УБС-ын 110/35/10 кВ-ын Дорнод дэд станц (Т-1 болон Т-2, 25МВа)
- ТБС-ын 110/35/10 кВ-ын Баясгалант дэд станц (Т-1, 16МВа)

ДҮГНЭЛТ

2025 онд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь стратегийн төлөвлөлт, санхүүгийн тогтвортой байдал, технологийн шинэчлэл, стандартчиллын чиглэлээр цогц ажлуудыг хэрэгжүүлж, компанийн чадавхыг нэмэгдүүлхийг зорьж ажиллалаа. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд компани урт хугацааны хөгжлийн тодорхой чиглэлтэй болж, стратегийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоонд шилжин цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлсэн технологийн шинэчлэлүүд нь компанийн үйл ажиллагааны үр ашиг, шийдвэр гаргалтын чанарыг дээшлүүлэв.

Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрийн дагуу Баруун бүс болон Алтай-Улиастайн эрчим хүчний системийн дамжуулах сүлжээг нэгтгэн авснаар компанийн үйл ажиллагааны цар хүрээ мэдэгдэхүйц тэлж, 177.8 МВА хүчин чадалтай 11 дэд станц, 1,184.5 км шугамыг компанийн сүлжээнд нэгтгэн авлаа.

2025 онд системийн найдвартай ажиллагаа, дамжуулалтын хэмжээ, алдагдлын түвшин тогтвортой хадгалагдаж, нийт 8,621.0 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүч дамжуулан төлөвлөгөөг 102.0 хувиар биелүүлсэн нь өмнөх оноос 7.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Системийн оргил ачаалал 1,743 МВт-д хүрч, нийт 710 тасралт бүртгэгдсэн нь өмнөх оноос 19.9 хувиар буурсан.

“Дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх” төслийн хүрээнд 17 дэд станцын тоноглолын шинэчлэлийг бүрэн дуусгаж, 220 кВ-ын Зэс-Оюу дэд станцыг ашиглалтад оруулснаар импортын чадварыг нэмэгдүүлж, ухаалаг сүлжээний суурийг бэхжүүлэв.

БНХАУ-ын ӨМӨЗО-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулснаар бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагааг шинэ шатанд гаргав.

ISO 45001:2018 хөдөлмөрийн аюулгүй байдлын болон MNS ISO/IEC 17025:2018 лабораторийн стандартуудыг амжилттай нэвтрүүлснээр байгууллагын аюулгүй ажиллагаа, техникийн чадавх олон улсын жишигт хүрэв.

SCADA системийг өргөтгөн, GIS суурьтай Grid Portal-ыг нэвтрүүлснээр өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоонд шат дараатай шилжих суурь бүрдлээ.

2025 онд ажилтнуудын цалинг нэмэгдүүлж, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгосны үр дүнд ажиллах хүчний эргэлтийг тогтвортой хэмжээнд хадгалсан.

2025 онд нийт орлого 671,037.4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 20.4 хувиар өссөн бол нийт зардал 688,168.6 сая төгрөгөөр бүртгэгдлээ. Гадаад зээлийн хүү, валютын ханшийн зөрүү болон томоохон төслүүдийн санхүүжилтийн нөлөөгөөр татварын дараахаар 17,136.2 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан боловч төлөвлөсөн алдагдлыг 8.3 хувиар бууруулсан нь зардлын хяналт, удирдлагын зохион байгуулалтын оновчтой арга хэмжээний бодит үр дүн байв.

Балансын бүтцэд урт хугацаат зээл давамгайлсан хэвээр байгаа бөгөөд нийт өр төлбөр нийт хөрөнгийн 62.7 хувийг эзэлж байна. Том чадлын хуримтлуур болон сүлжээний шинэчлэлийн төслүүд стратегийн өндөр ач холбогдолтой хэдий ч валютын ханшийн хэлбэлзэл компанийн ашигт ажиллагаанд мэдрэмтгий нөлөөлж байгаа тул санхүүгийн тогтвортой байдлыг хангахад эрсдэлийн удирдлагын бодлогыг цаашид бэхжүүлэх шаардлагатай байна.

Тайлант онд компанийн дунд болон урт хугацааны хөгжлийн чиглэлийг шинжлэх ухаанд суурилсан арга зүйгээр тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог сайжруулан, хэрэгжилтийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд онцгой анхаарав. Стратеги төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгосноор удирдлагын шийдвэр гаргалт илүү өгөгдөлд суурилсан, нэгдсэн чиг баримжаатай болж, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үндэслэл сайжирсан.

Дотоод мэдээллийн системүүдийг өгөгдлийн сангийн түвшинд интеграцчилж, дата менежментийн системийг (Dashboard) сайжруулснаар өмнө нь гар ажиллагаагаар хийгддэг байсан тооцоолол, тайлагналын процессууд автоматжиж, бодит цагийн горимоор мэдээлэл боловсруулах боломж бүрдлээ. Үүний үр дүнд ажлын гүйцэтгэлийн хугацаа богиносж, хүний хүчин зүйлээс шалтгаалах алдаа буурч, удирдлагын мэдээллийн чанар, шуурхай байдал мэдэгдэхүйц сайжрав. Мөн үүлэн технологид суурилсан хадгалалтын шийдлүүдийг нэвтрүүлснээр мэдээллийн төвлөрөл, хүртээмж, аюулгүй байдал шинэ түвшинд хүрсэн.

Техник ашиглалт, найдвартай ажиллагааны чиглэлээр реле хамгаалалт, автоматикийн тохируулга, хэмжүүрийн трансформаторын шалгалт, баталгаажуулалтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, дэд станц, шугам тоноглолын хамгаалалтын системүүдийн харилцан үйлчлэлийг иж бүрэн шалгасан. Ингэснээр цахилгаан дамжуулах сүлжээний аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах техникийн бэлэн байдлыг тогтвортой хадгаллаа.

Цаашид санхүүгийн тогтвортой байдал, валютын эрсдэлийн удирдлага, дижитал шилжилт, ухаалаг сүлжээний шийдлүүдийг эрчимжүүлэх нь компанийн тогтвортой өсөлтийн үндсэн чиглэл хэвээр байна. 2026 онд компани нь удирдлага, стратеги, бодлогын уялдаа холбоог улам бэхжүүлж, дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтыг хэрэгжилтэд бодитой ахиц гаргах жил байхаар зорин ажиллана. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд зардлын хяналтыг сайжруулж, хөрөнгийн удирдлага, нөөцийн үр ашигтай ашиглалтыг нэмэгдүүлэх, валютын болон санхүүгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгоход онцгой анхаарна.

Мөн хүний нөөцийн чадавхыг тасралтгүй хөгжүүлж, мэргэшсэн, тогтвортой баг бүрдүүлэхийн зэрэгцээ эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлж, үйл ажиллагааны сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ. Дижитал шилжилт, автоматжуулалтыг эрчимжүүлж, мэдээллийн нэгдсэн сан, цахим удирдлагын шийдлүүдийг өргөжүүлэх замаар ажлын бүтээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.

Инноваци, ногоон эрчим хүчний шилжилт, шинэ технологийн нэвтрүүлэлтийг дэмжиж, дамжуулах сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, эрчим хүчний аюулгүй байдлыг баталгаажуулна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулж, осол эрсдэлийг бууруулан аюулгүй ажлын орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ засвар үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл, чанарыг шинэ түвшинд хүргэхийг зорьж ажиллана.

ШИЛДЭГ 10 АЖИЛ

1. ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ: Германы сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд дэд станцуудын тоноглол шинэчлэх барилга угсралтын ажил 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр эхэлж Сүхбаатар, Налайх, Баянчандмань, Айраг, Хот, Бугант, Хялганат, Хөтөл, Баясгалант, Төв, Шарын гол, Баруунхараа, Бор-Өндөр, Үйлдвэр, Орхон, Хархорин, Булган зэрэг 17 дэд станцын ажлыг бүрэн дуусгаж, 2026 онд үлдсэн 15 дэд станцын ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажил хангагдаад байна.



9 тонн тос бүхий 110 кВ-ын тосон таслуур



600 кг тос бүхий 35 кВ-ын тосон таслуур






Хоёрдогч хэлхээний тоноглол



2. ЗЭС-ОЮУ ДЭД СТАНЦЫН БАРИЛГА УГСРАЛТ: Монгол Улсад БНХАУ-аас цахилгаан эрчим хүч импортлох, Төвийн бүсийн цахилгаан хангамжийг сайжруулах


төслийн хүрээнд 220 кВ-ын Зэс-Оюу дэд станцын ил хуваарилах байгууламж болон 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг амжилттай дуусгаж, хүчдэл дор залгав.



3. АЛТАЙ-УЛИАСТАЙН САЛБАР БОЛОН БАРУУН БҮСИЙН САЛБАРЫГ БАЙГУУЛАВ. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоол, Эрчим хүчний найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор Алтай-Улиастайн болон Баруун бүсийн салбарыг байгуулав. Шинэ салбар байгуулсантай холбогдуулан 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр салбарын удирдлагуудыг томилж, хөдөлмөрийн гэрээ байгууллаа.



4. 2025-2035 ОНД НИЙСЛЭЛИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ: Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг дарга нарын 2025.01.31-ний өдрийн А/55, А/124 дугаар хамтарсан тушаал, захирамжаар Улаанбаатар хот орчмын 2035 он хүртэлх өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах төлөвлөлт боловсруулах ажлын хэсэг томилогдсон. Тухайн ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд 2025-2035 онд дамжуулах болон түгээх сүлжээнд шинээр барих шугам, дэд станцуудын хүчдэлийн түвшин, чадал зэрэг техникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлж, одоогийн сүлжээнд холбох техникийн шийдлийг гаргах, байршил трасс сонгох, шаардагдах хөрөнгө зардлын урьдчилсан тооцоог хийх ажлуудыг 2025 оны 2-р сараас 6-р сар хүртэл нийт 4 сарын хугацаанд УБЦТС ТӨХК-ийн Хөгжлийн хөтөлбөрийн нэгжтэй хамтарч гүйцэтгэсэн. Цахилгаан хангамжийн төлөвлөлтөд орсон шинээр баригдах болон өргөтгөл шинэчлэл хийгдэх эхний ээлжийн 13 дэд станцын зураг төслийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан хийгдэж байгаагаас Дамбадаржаа, Богд дэд станцуудын барилга угсралтын ажил хийгдээд явж байна.






5. ТОСНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ, ӨНДӨР ХҮЧДЛИЙН ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАВ.

Өндөр хүчдэлийн тосны химийн лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын сорилт, шалгалт, тохируулгын шаардлагыг бүрэн хангаж 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Үндэсний итгэмжлэлийн төвөөс TL 216 дугаартай итгэмжлэлийн гэрчилгээг

амжилттай гардан авсан. Итгэмжлэл авснаар лабораторийн үйл ажиллагаа дэс дараалалтай стандартчилагдаж, хууль, стандартын шаардлагыг ханган, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн итгэлийг бэхжүүлэх ач холбогдолтой бөгөөд лабораторийн шинжилгээний үр дүн нь үнэн зөв, найдвартай байдал албан ёсоор баталгаажиж, дотоодын болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх боломж бүрдсэн. Мөн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК хамтын ажиллагааны хүрээнд ШУТИС-ийн Эрчим Хүчний Инженерийн сургуулийн "Өндөр хүчдэлийн туршилт судалгааны лаборатори"-г иж бүрэн шинэчлэн тохижуулж 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хүлээлгэн өглөө.

6. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах тухай гэрээ, Диспетчерийн зохицуулалтын гэрээ байгуулагдлаа. Монгол Улсын эрчим хүчний систем Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ны эрчим хүчний системтэй холбох ажлын хүрээнд 2025 оны 12-р сарын 16-ны өдөр Монгол Улсын Эрчим хүчний яаманд холбогдох талуудын төлөөлөл "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ" болон "Диспетчерийн зохицуулалтын гэрээ"-үүдэд гарын үсэг зурлаа. Энэхүү түүхэн үйл ажиллагаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ны "Эрчим хүчний групп" ХХК (IMPC)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн дарга Жан Хайфэн, мөн орны "Эрчим хүчний Олон улсын хамтын ажиллагааны компани"-ийн (IMPIC) ТУЗ-ийн дарга Ван Пэнфэй, Монгол Улсын Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Дашдаваа, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Балжинням нар болон албаны бусад хүмүүс оролцов. Энэхүү үйл явдал нь манай улс хөрш хоёр оронтойгоо эрчим хүчний салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд шинэ алхам болж улмаар нэгдсэн сүлжээний найдвартай, тогтвортой байдал дээшлэх давуу талтай юм.



7. ХЭМАБ-ЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЭВ
Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь олон улсын ISO 45001:2018 стандартын шаардлагад нийцсэн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү тогтолцоо нь осол, эрсдэлийг системтэйгээр бууруулах, ажилтнуудын аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих үр дүнтэй шийдэл болж байна. Бид хууль, журам, стандартуудыг бүрэн мөрдөхөөс гадна аюулгүй байдлын соёлыг байгууллагын бүх түвшинд төлөвшүүлэхийг зорьдог. Тасралтгүй сайжруулалтын зарчмаар аюулгүй, эрүүл ажлын орчныг бүрдүүлэх нь бидний гол зорилт юм. Ингэснээр ажилтнуудын оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг хангах чухал суурийг бий болгож байна. ЦДҮС ТӨХК нь зөвхөн чанартай үйлчилгээ үзүүлэхээс гадна нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлж, аюулгүй байдлын жишиг тогтоохыг эрхэмлэн ажиллаж байна.



8. ХОСМОГ СУРГАЛТ: Монгол Улсын Тогтвортой Эрчим Хүчний чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд 110/35/10 кВ-ын Туул дэд станцыг түшиглэн Өндрийн сургалтын төвийг нээлээ. Тус төвд “Өндөр хүчдэлийн техникч”-ийн хосмог сургалт явуулах, багш, дадлагажуулагчдын чадавхыг сайжруулах, бодит орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрэгжүүлэх, сэлгэн залгалт, өндөрт ажиллах дадлыг төлөвшүүлэх боломжтой юм. Энэхүү төслийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлсэн.





9. ЖАЙКА БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ:

Японы олон улсын техникийн хамтын ажиллагааны байгууллага буюу Жайкагаас Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д 2 сая америк долларын өртөг бүхий явуулын гэмтэл оношилгооны төхөөрөмжийг буцалтгүй тусламж болгон хүлээлгэн өгөхөөр болов. Явуулын гэмтэл оношилгооны төхөөрөмжтэй болсноор алслагдсан

дэд станц болон цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан гэмтлийг оношилж илрүүлэх ажлыг хөнгөвчлөхийн зэрэгцээ төлөвлөгөөт үзлэг шалгалт явуулахад дорвитой ахиц гарах юм.

Мөн 220 кВ-ын Багануур-Чойр цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Их хурлаар соёрхон баталж, олон улсын тендерийн баримт бичгийг боловсруулаад байна.

10. УЛААНБААТАР САЛБАРЫН БАРИЛГЫН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ:

Улаанбаатар салбарын ажилчдын тав тухтай, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сургалт, лабораторийн зориулалттай хоёр давхар шинэ барилгын угсралтыг бүрэн хийж ашиглалтад оруулав. Мөн оффисын 1, 2 дугаар давхарын дотор засварын ажлыг гүйцэтгэж, гадна орчны тохижилт, ногоон байгууламж байгуулав. Ингэснээр ажилчдын сэтгэл ханамж, сургалтын чанар, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг бодитоор нэмэгдэж, урт хугацаанд тогтвортой хөгжлийг дэмжих суурь бүрдэв.



2025 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ		
<i>д/д</i>	<i>Зорилт</i>	<i>Биелэлт</i>
1	2025 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлэх	99%
2	Осол авааргүй ажиллах	95%
3	Монгол Улсын Засгийн Газраас 2025 оны Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор 2035 он хүртэлх Улаанбаатар хотын дамжуулах сүлжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	99%
4	Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон ХБНГУ-ын KfW банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн угсралтын ажлыг 50% буюу түүнээс дээш гүйцэтгэлд хүргэх, Чойр-Сайншанд ЦДАШ, 110/10 кВ-ын “Өргөө” дэд станцын төслүүдийг эхлүүлэх	92%
5	Компанийн хэмжээнд дижитал шилжилтийг хурдасгах хүрээнд SCADA системийг өргөтгөх, хяналтын самбар (Dashboard), ухаалаг тоолуур, хэмжүүр болон тоон дэд станцын технологийг нэвтрүүлэх	96%
6	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд болон батарей хуримтлуурын станцыг үр ашиг, үйлдвэрлэлийн өгөгдөл дээр дүн шинжилгээ хийж, дамжуулах сүлжээний ногоон эрчим хүчний оролцоог нэмэгдүүлэх	83%
7	Дамжуулах сүлжээнд инноваци шинэ техник технологийг нэвтрүүлэх хүрээнд 500 кВ-ын ЦДАШ, дэд станц, PASS систем, E-HOUSE зэрэг дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх	99%
8	Зэс-Оюу 220 кВ-ын ИХБ-ийг барьж, ашиглалтад оруулах замаар БНХАУ-ын ӨМӨЗО-оос импортлох цахилгаан эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх	100%
9	2025 оны эрчим хүчний салбарын хэмжээнд “Салбарын инженер техникийн ажилтан, албан хаагчдын жил” болгон зарласантай холбоотойгоор хүний нөөц чадавх, сургалт бүтээмжийг чанарыг дээшлүүлэх	100%
10	Компанийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх, засаглалын менежментийг сайжруулахад олон улсын стандартыг нэвтрүүлэх	99%
БИЕЛЭЛТ /101 АРГА ХЭМЖЭЭ/		96.4%

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь үндсэн чиг үүрэг,
зорилтын хүрээнд 2026 онд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн
ажиллана**

1. Удирдлага, стратеги, бодлогын уялдаа холбоог бэхжүүлж, компанийн дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтыг оновчтой хэрэгжүүлэх **/21 ажил/**
2. Санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг хангаж, зардлын хяналт, хөрөнгийн удирдлага, нөөцийн үр ашигтай ашиглалтыг дээшлүүлэх **/13 ажил/**
3. Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлж, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх **/14 ажил/**
4. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлж, үйл ажиллагааны сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх **/9 ажил/**
5. Дижитал шилжилт, автоматжуулалтыг эрчимжүүлж, үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх /мэдээллийн сан, цахимжуулалт **/12 ажил/**
6. Инноваци, ногоон эрчим хүчний шилжилт, шинэ технологийн нэвтрүүлэлтийг дэмжиж, үйл ажиллагааны бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (судалгаа хөгжил, төлөвлөлт) **/11 ажил/**
7. Хамтын ажиллагаа, ил тод байдлын түвшинг дээшлүүлэх **/6 ажил/**
8. Дамжуулах сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, эрчим хүчний аюулгүй байдлыг баталгаажуулах **/19 ажил/**
9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулж, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх **/6 ажил/**
10. Засвар үйлчилгээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, чанарыг сайжруулж, тоноглолын найдвартай байдлыг хангах **/13 ажил/**

/124 ажил/